

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СНАГ-2023/156/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2023 он	Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Б.Долгоржав Утас: 261628 Цахим хаяг: dolgorjavb@audit.gov.mn Аудитор: М.Ганбаатар Утас: 261628 Цахим хаяг: Ganbaatar.m@audit.gov.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ШУДАРГА, ӨРСӨЛДӨӨН
ХЭРЭГЛЭГЧИЙН ТӨЛӨӨ ГАЗРЫН ДАРГА
Ц.УРТНАСАН ТАНАА

2023.02.17 № 07/302
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шударга, өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд улсын байцаагчийн шийдвэр, зөрчлийн хэрэгтэй холбоотой нийт 13,183,569.8 мянган төгрөгийн торгууль оногдуулснаас 21,400.0 мянган төгрөгийн торгуулийг улсын төсөвт төвлөрүүлж, 18,800.0 мянган төгрөгийн торгуулийг албадан гүйцэтгүүлэх хүсэлт шүүхэд хүргүүлж, 508,921.9 мянган төгрөгийн торгуулийг шүүхэд нэхэмжлэл гаргаж, 12,614,447.8 мянган төгрөгийн торгуулийн сайн дураар биелүүлэх болон гомдол гаргах хугацаа нь дуусаагүй байна.

Тайлант онд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор сүлжээ хүнсний дэлгүүрүүдэд хяналт шалгалтын ажлыг хийж кассын үнэ болон лангууны үнэ зөрүүтэй аж ахуй нэгжүүдэд зөрчлийн хэрэг үүсгэж Зөрчлийн тухай хуульд зааснаар хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, тус аж ахуй эрхлэгчдэд тус бүр 5 сая төгрөгийн торгууль ногдуулж ажилласан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд өөрийн эзэмшлийн албан конторын зориулалттай 3,597 м.кв газрыг 1,006,880.0 мянган төгрөгөөр үнэлүүлж, ТӨБЗГ-аас зөвшөөрөл авч данс бүртгэлд тусгаж ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгасан хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 92.7 хувьтай байна. Хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөсөн төсвийн гүйцэтгэл 99.8 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	39,651,647.90	30,194,247.00
33	АВЛАГА	2,819,424.90	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,819,424.90	0.00
35	БАРАА МАТЕРИАЛ	36,832,223.00	30,194,247.00
35400	Хангамжийн материал	36,832,223.00	30,194,247.00
35410	Бичиг хэргийн материал	11,652,647.00	6,242,503.00
35420	Аж ахуйн материал	7,561,262.00	8,651,732.00
35440	Түлш, шатах тослох материал	4,534,726.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	13,083,588.00	15,300,012.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	130,005,046.96	1,115,600,969.46
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	130,005,046.96	1,115,600,969.46
39200	Биет хөрөнгө	128,942,546.96	103,368,469.46
39203	Авто-тээврийн хэрэгсэл	57,257,530.00	34,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-42,973,552.50	-34,900,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	124,820,354.00	122,071,154.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,095,469.41	-66,704,918.57
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,504,709.00	58,504,709.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,571,024.13	-10,502,474.97
39300	Биет бус хөрөнгө	1,062,500.00	1,012,232,500.00
39301	Программ хангамж	66,688,490.00	6,540,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-65,625,990.00	-1,187,500.00
39303	Бусад биет бус хөрөнгө	16,092,500.00	1,006,880,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-16,092,500.00	0.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	169,656,694.86	1,145,795,216.46
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	4,616,864.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	4,616,864.00
41300	Өглөг	0.00	4,616,864.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	723,000.00
41360	Бусад өглөг	0.00	3,893,864.00
41361	Байгууллагад төлөх өглөг	0.00	3,893,864.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	169,656,694.86	1,141,178,352.46
51	Засгийн газрын хувь оролцоо	169,656,694.86	1,141,178,352.46
51100	Засгийн газрын оруулсан капитал	186,808,521.00	186,808,521.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	186,808,521.00	186,808,521.00
51200	Хуримтлагдсан үр дүн	-17,151,826.14	954,369,831.46
51210	Өмнөх үеийн үр дүн	-111,674,744.23	-17,151,826.14
51220	Тайлант үеийн үр дүн	94,522,918.09	971,521,657.60
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	169,656,694.86	1,145,795,216.46

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,200,742,109.00	1,869,824,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280,000.00	1,023,169,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	280,000.00	1,023,169,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	280,000.00	1,023,169,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	280,000.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	0	1,023,169,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,200,462,109.00	846,655,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,110,837,139.00	846,655,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,014,861,300.00	846,655,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	95,975,839.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,624,970.00	0
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	43,624,970.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,000,000.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,103,375,172.40	887,745,519.90
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,103,375,172.40	887,745,519.90
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,057,785,389.17	859,396,208.63
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	572,944,080.09	593,653,944.57
210101	Үндсэн цалин	497,524,059.00	558,366,967.26
210102	Нэмэгдэл	48,222,204.09	26,778,977.31
210103	Унаа хоолны хөнгөлөлт	27,197,817.00	8,508,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	77,980,797.82	75,502,564.83
210201	Тэтгэврийн даатгал	52,228,117.20	51,444,844.05
210202	Тэтгэмжийн даатгал	5,919,227.62	6,040,205.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,095,587.50	4,729,064.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,248,896.80	1,208,041.04
210205	Эрүүл мэндийн даатгал	13,488,968.70	12,080,410.39
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,706,655.92	14,302,810.23
210301	Гэрэл, цахилгаан	0	76,241.23
210304	Байрны түрээс	16,706,655.92	14,226,569.00
2104	Хангамж, бараа материалын зардал	193,629,341.64	85,501,220.00
210401	Бичиг хэрэг	58,452,457.00	18,191,368.00
210402	Тээвэр, шатахуун	16,156,274.00	32,163,426.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,045,079.64	24,250,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	98,975,531.00	10,895,726.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	453,500.00	0
210601	Багаж, техник, хэрэгсэл	453,500.00	0.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	354,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	200,000.00	354,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	159,386,432.11	61,947,014.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	130,253,804.11	43,675,800.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,020,000.00	0.00
210803	Даатгалын үйлчилгээ	16,501,270.00	3,471,150.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	160,734.00	69,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,941,500.00	14,172,900.00

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	465,124.00	535,964.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	36,484,581.59	28,134,655.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,500,000.00	1,118,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,984,581.59	27,016,155.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,589,783.23	28,349,311.27
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,422,687.29	0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,422,687.29	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,723,737.00	27,931,715.50
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	23,523,251.40	25,526,419.50
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,200,485.60	2,405,296.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,443,358.94	417,595.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,443,358.94	417,595.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	97,366,936.60	982,079,380.10
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,844,018.51	10,557,722.50
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	2,844,018.51	0.00
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	0.00	10,557,722.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	94,522,918.09	971,521,657.60

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,200,742,109.00	846,655,100.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	280,000.00	0.00
120	Нийтлэг татварын бус орлого	280,000.00	0.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	280,000.00	0.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	280,000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,200,462,109.00	846,655,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,110,837,139.00	846,655,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,014,861,300.00	846,655,100.00
131005	Хөрөнгийн санхүүжилт	95,975,839.00	0.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	89,624,970.00	0.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	43,624,970.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	46,000,000.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,091,506,788.00	846,655,100.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,091,506,788.00	846,655,100.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,047,665,335.53	818,763,804.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	574,448,437.73	593,580,100.00
210101	Үндсэн цалин	408,395,260.73	416,806,437.90
210102	Нэмэгдэл	113,133,177.00	108,468,192.40
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,920,000.00	63,605,469.70
210104	Урамшуулал	0.00	4,700,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	76,133,308.13	72,492,000.00
210201	Тэтгэврийн даатгал	54,677,808.13	49,294,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,363,600.00	5,799,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,291,100.00	4,639,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,072,500.00	1,159,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,728,300.00	11,598,800.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	16,706,655.92	5,726,110.23
210301	Гэрэл, цахилгаан	82,922.92	76,241.23
210304	Байрны түрээс	16,623,733.00	5,649,869.00
2104	Хангамж, бараа материалын зардал	65,150,524.75	54,319,444.00
210401	Бичиг хэрэг	12,539,059.00	8,441,700.00
210402	Тээвэр, шатахуун	20,218,000.00	9,827,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	16,696,865.75	23,601,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	15,696,600.00	12,448,444.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,196,950.00	4,942,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,795,450.00	4,019,900.00
210604	Урсгал засвар	1,401,500.00	922,500.00
2107	Томилот, зочны зардал	761,000.00	354,000.00
210702	Дотоод албан томилот	761,000.00	354,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	260,268,459.00	85,652,150.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	229,842,711.00	54,447,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	0.00

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210803	Даатгалын үйлчилгээ	16,501,270.00	18,272,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	228,134.00	69,200.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	11,187,220.00	12,404,500.00
210807	Газрын төлбөр	465,124.00	437,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,000,000.00	1,697,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,000,000.00	689,100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	1,008,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,841,452.47	27,891,295.77
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,422,687.29	0.00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,422,687.29	0.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	25,975,406.24	27,473,700.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	24,883,406.24	26,552,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,092,000.00	921,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	16,443,358.94	417,595.77
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,443,358.94	417,595.77
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	109,235,321.00	0.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	109,236,743.00	0.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	109,236,743.00	0.00
2200	Дотоод эх үүсвэрээр	109,236,743.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	109,236,743.00	0.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-109,236,743.00	0.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,422.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,422.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,808,521.00	0.00	-111,674,744.23	75,133,776.77
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,808,521.00	0.00	-111,674,744.23	75,133,776.77
3	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	94,522,918.09	94,522,918.09
4	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	186,808,521.00	0.00	-17,151,826.14	169,656,694.86
5	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	186,808,521.00	0.00	-17,151,826.14	169,656,694.86
6	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	971,521,657.60	971,521,657.60
7	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	186,808,521.00	0.00	954,369,831.46	1,141,178,352.46

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	847,850,700.00	846,237,504.23	1,613,195.77	99.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	847,850,700.00	846,237,504.23	1,613,195.77	99.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	819,061,400.00	818,763,804.23	297,595.77	100.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	593,580,100.00	593,580,100.00	0.00	100.0
210101	Үндсэн цалин	427,401,900.00	416,806,437.90	10,595,462.10	97.5
210102	Нэмэгдэл	113,258,200.00	108,468,192.40	4,790,007.60	95.8
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,920,000.00	63,605,469.70	10,685,469.70	120.2
210104	Урамшуулал	0	4,700,000.00	-4,700,000.00	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,492,000.00	72,492,000.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	49,294,600.00	49,294,600.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,799,300.00	5,799,300.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,639,500.00	4,639,500.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,159,800.00	1,159,800.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,598,800.00	11,598,800.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,843,300.00	5,726,110.23	117,189.77	98.0
210301	Гэрэл, цахилгаан	77,100.00	76,241.23	858.77	98.9
210304	Байрны түрээс	5,766,200.00	5,649,869.00	116,331.00	98.0
2104	Хангамж, бараа материалын зардал	54,319,800.00	54,319,444.00	-356.00	100.0
210401	Бичиг хэрэг	8,441,700.00	8,441,700.00	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	9,827,600.00	9,827,600.00	0.00	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	23,601,700.00	23,601,700.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,448,800.00	12,448,444.00	356.00	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,942,400.00	4,942,400.00	0.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,019,900.00	4,019,900.00	0.00	100.0
210604	Урсгал засвар	922,500.00	922,500.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	360,200.00	354,000.00	6,200.00	98.3
210702	Дотоод албан томилолт	360,200.00	354,000.00	6,200.00	98.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	85,826,000.00	85,652,150.00	173,850.00	99.8%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,447,200.00	54,447,200.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	18,283,000.00	18,272,250.00	10,750.00	99.9
210804	Тээврийн хэрэгслийн татвар	232,300.00	69,200.00	163,100.00	29.8
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	12,404,500.00	12,404,500.00	0.00	100.0
210807	Газрын төлбөр	437,000.00	437,000.00	0.00	100.0

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,697,600.00	1,697,600.00	0.00	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	689,100.00	689,100.00	0.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,008,500.00	1,008,500.00	0.00	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,789,300.00	27,473,700.00	1,315,600.00	95.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,195,600.00	0	1,195,600.00	0.0
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	1,195,600.00	0	1,195,600.00	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	27,593,700.00	27,473,700.00	120,000.00	99.6
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	26,552,700.00	26,552,700.00	0.00	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,041,000.00	921,000.00	120,000.00	88.5
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	847,850,700.00	846,237,504.23	1,613,195.77	99.8
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	847,850,700.00	846,237,504.23	1,613,195.77	99.8
310001	Улсын төсвөөс санхүүжих	847,850,700.00	846,237,504.23	1,613,195.77	99.8
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.0
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	36	36	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	32	32	-	100.0
620003	Үйлчлэх ажилтан	3	3	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 10,003.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 689.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,008.7 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 8,306.0 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

Аудитаар илэрсэн зөрчил 10,003.8 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдал түвшин 11,033,7 мянган төгрөгөөс бага тул **Өөрчлөлтгүй** дүгнэлт өгсөн.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолын дагуу ажлаас үндэслэлгүй үндэслэлгүй халагдсан ажилтанд, ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 16,461,634.00 төгрөг нэхэмжилснээс тайлант онд 689,100.00 төгрөгийг олгосон боловч буруутай этгээдээр төлүүлэх нөхцөлийг хангуулж ажиллаагүй байна.	1	689.1			1	689.1						
2	Төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчин танхимаар сургалт зохион байгуулж 1,008,700.00 төгрөгийн зардал гаргасан нь байна.	1	1,008.7			1	1,008.7						
3	Тайлант онд ХХОАТ-т 723,000.00 төгрөг, байгууллагад 3,893,864.00 төгрөгийн өр төлбөр үүсгэж ажилласан байна.	1	4,616.8					1	4,616.8				
4	Өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэргүйгээр Бараа материалын данснаас 19 нэр төрлийн 3,689,150.00 төгрөгийн бараа материалыг акталсан байна. Өмч хамгаалах байнгын зөвлөл нь данс бүртгэлээс хасах, устгах эд хөрөнгийн талаар дүгнэлт гаргаагүй, хяналт хэрэгжүүлж ажиллаагүй байна.	1	3,689.1					1	3,689.1				
5	Тус байгууллагын бараа материалын орлого, зарлагад дарга, нягтлан бодогч хяналт хэрэгжүүлж хэвшээгүй, анхан шатны баримт нь	1	-					1	-				

	шаардлагад нийцээгүй байгаа нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах эрсдэл бий болгосон байна.											
	Дүн	5	10,003.8			2	1,697.8	3	8,306.0			

4.2 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								
				Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн			
	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил											
1	Тус байгууллага нь тайлант онд нийт 166 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 159 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна	1								1	-	
	Дүн	1										
	Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил											
1	Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар нь 2017 онд боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт Шадар сайдын 2020 оны 145 дүгээр тушаалын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт, 2021 оны Сангийн сайдын 190 дугаар тушаалын "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" болон бусад холбогдох тогтоол, стандартын өөрчлөлтийг тусгаагүй байна.	1								1	-	
	Дүн	1										
	Нийт дүн	2								2		

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР